



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/302

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 /в/, 29.2 дахь заалт, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Өндөр сумын Дэнж багт байрлах 52 дугаар ус түгээх байр ашиглалтын шаардлага хангахгүй үйл ажиллагаа нь зогсож иргэд ундны усаар хангагдахгүй байгаа тул яаралтай шинээр ус түгээх байрыг барих ажилд шаардагдах 13200000 /Арван гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийг болзошгүй аварийн зардлаас зарцуулахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

2.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хотын захирагчийн алба /н.Түмэнжаргал/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ